

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН 2024 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Танилцуулга

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн тайланг худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д /цаашид “цахим систем” гэх/ нийтэлсэн төлөвлөгөө, түүний биелэлт, үр дүн болон гомдлын судалгаанд үндэслэн танилцуулж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нараас цахим системээр ирүүлсэн 2024 оны худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн дүгнээд, танилцуулгыг худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тендер шалгаруулалттай холбоотой гомдол, маргаан, тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл гэсэн бүтцийн дагуу бэлтгэлээ.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д зааснаар Монгол Улсын хэмжээнд 60 төсвийн ерөнхийлөн захирагч байна.

Худалдан авах ажиллагааны цахим системд улс, орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө зэрэг санхүүжилтийн эх үүсвэр, тогтолцоо зэргээс хамаарч Төрийн худалдан авах ажиллагааны газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Эрдэнэс монгол нэгдэл нь төсвийн ерөнхийлөн захирагч ангилалд бүртгэгдсэн бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг тодорхой харуулах үүднээс тус байгууллагуудыг системд бүртгэгдсэн ангиллаар авч үзлээ.

Тодруулбал, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Эрдэнэс тавантолгой” ХК зэрэг төрийн өмчит хуулийн этгээд нь “Эрдэнэс монгол нэгдэл” ангилалд, орон нутгийн өмчит хуулийн этгээдийг тухайн ерөнхийлөн захирагчийн ангилалд хамаарууллаа.




График 1. Худалдан авах ажиллагаа хэрэгжүүлсэн захиалагчийн тоо

Тайлан хугацаанд 64 төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 2,203 захиалагч худалдан авах ажиллагаа хэрэгжүүлсэн талаар мэдээлэл ирүүллээ. Үүнийг 2023 онтой харьцуулбал цахим системд тендер шалгаруулалт зохион байгуулсан захиалагчийн тоо 2024 онд 357 буюу 37 хувиар нэмэгдсэн байна. Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулж байгаа захиалагчийн тоо жил бүр өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд цаашид нэмэгдэх хандлага ажиглагдаж байна (График 1).

- **Худалдан авах ажиллагааны төсөвт өртөг, тендер шалгаруулалтын тоо:**

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020-2024 онуудын хооронд зарласан тендер шалгаруулалтын төсөвт өртгийн хэмжээ 5.7 их наяд төгрөгөөс 26.0 их наяд төгрөг болж, ойролцоогоор 4.5 дахин нэмэгдсэн байна (график 2).




График 2. Тендер шалгаруулалтын төсөвт өртөг ба тоо (их наяд төгрөг)

График 2-оос үзэхэд 2024 онд зохион байгуулсан тендер шалгаруулалтын төсөвт өртөг 2023 оноос 14.1 их наяд төгрөг буюу 116 хувиар нэмэгдсэн нь Нийслэлээс зарласан “Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро”-г барих төслийн бүтээн байгуулалтын ажил (Улаанбаатар хот)”, “Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хороолол”, “Эрдэнэс тавантолгой” ХК-аас зарласан “Цанхийн зүүн уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолт”, “Тавантолгой” ХК-аас зарласан “Хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажил /багцтай/” зэрэг төсөл арга хэмжээний төсөвт өртөгтэй холбоотой байна. Дээрх төсөл арга хэмжээний төсөвт өртөг 11.1 их наяд төгрөг буюу 2024 онд зохион байгуулсан нийт тендер шалгаруулалтын төсөвт өртгийн 42 хувийг эзэлж байна.

Нөгөөтээгүүр, 2024 оны нийт зарласан тендер шалгаруулалт 2023 оноос 4,071 буюу 29.8 хувиар нэмэгдсэн байна. Дээрх үзүүлэлтээс үзэхэд зохион байгуулж байгаа тендер шалгаруулалт нь төсөвт өртгийн өсөлттэй шууд хамааралгүй байна. Харин цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулсан захиалагчийн тоо нэмэгдсэн, бага төсөвт өртөг бүхий олон тендер шалгаруулалт зарласантай холбоотой байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөөнд нийт 32.0 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 22,481 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалт зохион байгуулахаар төлөвлөсөн байх боловч 26.0 их наяд төгрөгийн төсөвт өртэйг 17,718 тендер шалгаруулалт зарласан байна. Гүйцэтгэл төсөвт өртгийн 81 хувь, тендер шалгаруулалтын 79 хувьтай байна (Хүснэгт 1).

Өнгөрсөн онд гүйцэтгэлийн хувь сүүлийн таван жилийн хугацаанд хамгийн өндөр үзүүлэлт болж байгаа хэдий ч жил бүр төсөвт өртгийн 20-30 хувь, тооны хувьд 20-25 хувьтай тэнцэх тендер шалгаруулалтыг зарлагдахгүй хэвээр байна.

Хүснэгт 1.Төлөвлөлт, тайлан (их наяд.төгрөг)

Он	Төлөвлөгөө			Тайлан		
	Төсөвт өртөг	Өсөлт /өмнөх оноос/	ТШ-ын тоо	Төсөвт өртөг	Өсөлт /өмнөх оноос/	ТШ-ын тоо
2023	14.8	2.8%	17,576	11.9	18.59%	13,647
2024	32.0	116.0%	22,481	26.0	119.01%	17,718

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гол зорилго нь батлагдсан төсөвт үндэслэн бараа, ажил, үйлчилгээний онцлогийг харгалзан төлөвлөж, тухайн жилийн худалдан авах ажиллагааг үр ашигтай хэрэгжүүлэхэд оршино. Захиалагч бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд эхлүүлж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нь тухайн захиалагчийн хэрэгцээт бараа, ажил, үйлчилгээг цаг тухайд нь тасралтгүй хангах төдийгүй төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Дээрх төлөвлөгөөний төсөвт өртөг болон тоо хэмжээг 2023 онтой харьцуулахад төсөвт өртөг 116 хувиар, тоо хэмжээ 27.9 хувиар тус тус өссөн дүнтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагч нар 2024 онд нийт төлөвлөгөөнд тусгасан нийт төсөвт өртгийн 19 хувь буюу 6.1 их наяд төгрөг бүхий 4,700 орчим тендер шалгаруулалт зарлаагүй байна.

Зарлагдаагүй тендер шалгаруулалтыг санхүүжилтийн эх үүсвэрээр авч үзвэл 3.3 их наяд төгрөг буюу 54.7 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, 2.01 их наяд төгрөг буюу 33.3 хувийг орон нутгийн төсөв, 0.6 их наяд төгрөг буюу 9.9 хувийг улсын төсөв, үлдэх хувийг бусад эх үүсвэр эзэлж байна.

Тайлант хугацаанд зохион байгуулагдсан нийт тендер шалгаруулалтыг нэг тэрбум хүртэлх болон нэг тэрбумаас дээш гэсэн хоёр ангилалд хуваан авч үзлээ (хүснэгт 2).


Хүснэгт 2-оос харахад нэг тэрбум хүртэлх төсөвт өртөгтэй тендер шалгаруулалт 15,777 буюу 89.1 хувийг эзэлж байна. Энэ нь нийт тендер шалгаруулалтад нэг тэрбумаас доош төсөвт өртөгтэй тендер шалгаруулалт давамгайлж буйг харуулж байна.

Хүснэгт 2. Тендер шалгаруулалтын төсөвт өртөг (1 тэрбум хүртэлх ба түүнээс дээш)

Ангилал	Тоо		Тендер шалгаруулалтын төсөвт өртөг	
	Нийт тендер шалгаруулалтын Тоо	Эзлэх хувь	Төсөвт өртөг (Их наяд төгрөг)	Эзлэх хувь

Нэг тэрбум хүртэлх төсөвт өртөгтэй	15,777	89.1%	2.6	10.0%
Нэг тэрбумаас дээш төсөвт өртөгтэй	1,941	10.9%	23.4	90.0%

Харин, нэг тэрбумаас дээш төсөвт өртөгтэй тендер шалгаруулалт 1,941 буюу 10.1 хувийг эзэлж байна. Гэсэн хэдий ч эдгээр төсөл арга хэмжээний төсөвт өртөг 23.4 их наяд төгрөг буюу зарлагдсан тендер шалгаруулалтын нийт төсөв өртгийн 90.0 хувийг эзэлж байна.



1 тэрбум хүртэлх төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтыг нарийвчлан 50.0-аас 500 сая төгрөг, түүнээс дээш гэж хуваан авч үзвэл 50 сая хүртэл төсөвт өртөгтэй тендер шалгаруулалт 27.8 хувь, 50-100 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендер шалгаруулалт 23.9 хувь, 100-150 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендер шалгаруулалт 9.8 хувь, 150-200 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендер шалгаруулалт 6.6 хувь, 500 саяас дээш төгрөгийн төсөвт өртөгтэй тендер шалгаруулалт 17.4 хувийг эзэлж байна.


Нийт тендер шалгаруулалтын 51.7 хувь нь 20-100 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендер шалгаруулалт эзэлж байна.

График 3. Тендер шалгаруулалтын төсөвт өртөг

- Санхүүжилтийн эх үүсвэрийн талаар:

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд зохион байгуулсан тендер шалгаруулалтын төсөвт өртгийг санхүүжилтийн эх үүсвэрээр нь улсын төсөв, орон нутгийн төсөв, өөрийн хөрөнгө, зээл тусламж, бусад гэсэн ангиллаар нэгтгэлээ. Засгийн газрын холбогдох санг бусад ангилалд, “Эрдэнэс монгол нэгдэл”-ийн төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө болон төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийг өөрийн хөрөнгө ангилалд, улсын төсвийн хөрөнгө оруулалт болон урсгал зардлыг улсын төсөв ангилалд орууллаа (график 4).

График 4. Санхүүжилтийн эх үүсвэр (тэрбум төгрөг)



Графикт үзүүлснээр нийт худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний санхүүжилтийн 11,628.7 тэрбум төгрөг буюу 43 хувийг өөрийн хөрөнгө, 8,632.1 тэрбум төгрөг буюу 33 хувийг орон нутгийн төсөв, 5,473.6 тэрбум төгрөг буюу 21 хувийг улсын төсөв, 405.2 тэрбум төгрөг буюу 2 хувийг зээл тусламж, 202.1 тэрбум төгрөг буюу 1 хувийг бусад эх үүсвэр эзэлж байна.

Дээрх үзүүлэлт 2023 онд 8,562.2 тэрбум төгрөг буюу 72 хувийг өөрийн хөрөнгө, 1,487.9 тэрбум төгрөг буюу 13 хувийг улсын төсөв, 1,401.2 тэрбум төгрөг буюу 12 хувийг орон нутгийн төсөв, 290.7 тэрбум төгрөг буюу 2 хувийг бусад, 1.5 тэрбум төгрөг буюу 1 хувийг зээлж тусламжийн эх үүсвэр эзэлж байсан байна.

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар:

Худалдан авах ажиллагааны цахим системд 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар зарлах 936 тендер шалгаруулалт төлөвлөгдсөн байна. Үүнээс 4,206.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 836 (92.2%) тендер шалгаруулалт зарлагдсан, 276.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 73 (7.8%) тендер шалгаруулалт зарлагдаагүй байна. Зарлаагүй тендер шалгаруулалтын 63 нь яам, харьяа агентлаг, 4 нь нийслэл, 6 орон нутагт хамаарч байна.

Нийт зарласан тендер шалгаруулалтуудыг аргаар ангилбал нээлттэй аргаар 822, харьцуулалтын аргаар 28, гэрээ шууд байгуулах аргаар 13 тендер шалгаруулалт тус тус зохион байгуулсан байна.

Тендер шалгаруулалт зохион байгуулахаар төлөвлөсөн хугацааны хувьд 2023 оны 12 дугаар сард 142 (15.2%), 2024 оны нэгдүгээр сард 297 (31.7%), хоёрдугаар сард 115 (12.3%), гуравдугаар сард 133 (14.2%) зарлахаар төлөвлөсөн буюу нийт тендер шалгаруулалтын 73 хувийг жилийн эхний улиралд зохион байгуулахаар тусгасан байна.



График 5. УТХО-ын тендер шалгаруулалт төлөвлөлт ба хэрэгжилт /хугацаагаар/



дахин бага байх тул төлөвлөлт, хэрэгжилтийг оновчтой төлөвлөхөд анхаарах нь зүйтэй байна. Түүнчлэн нийт тендер шалгаруулалтын 86% хугацаандаа эхлээгүй байх ба хугацаагаар авч үзвэл 45 орчим хувь 1-3 сарын дараа зарлагдсан байна.

Хуулийн 35 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэгт зааснаар нээлттэй тендер шалгаруулалтын тендер хүлээн авах эцсийн хугацаа ажлын 15-аас дээш, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт тендер хянан үзэх, үнэлгээ хийх хугацаа ажлын 15 өдөр байхаар тогтоосон.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар зарлагдсан тендер шалгаруулалтыг зарласнаас захиалагч шийдвэр гарах хүртэлх дундаж хугацаа нээлттэй тендер шалгаруулалтын аргын хувьд 43 хоног буюу ойролцоогоор ажлын 30-31 өдрийн дотор гарсан байгаа нь улсын дунджаас ажлын 4 өдрөөр илүү байна.

Тайлант хугацаанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар зарлагдсан тендер шалгаруулалт, түүний 172 багцтай холбогдуулан давхардсан тоогоор ирүүлсэн 248 гомдлыг хянан шийдвэрлэсэн байна. Эдгээр гомдлын 77.4 хувь үндэслэлтэй, 22.6 хувь үндэслэлгүй байна. Үүнээс үзэхэд захиалагчийн шийдвэрийн 77.4 хувь хууль тогтоомж, журамд нийцээгүй шийдвэр гарсан байна.

- **Бараа, ажил, үйлчилгээний төрөл:**

Тайлант хугацаанд 2024 онд зохион байгуулсан тендер шалгаруулалтыг бараа, ажил, үйлчилгээ гэсэн гурван төрлөөр ангилан төсөвт эзлэх хувийг гаргахад ажил гүйцэтгэх тендер шалгаруулалт 77 хувь буюу 19.9 их наяд төгрөг, бараа худалдан авах тендер шалгаруулалт 19 хувь буюу 5.0 их наяд төгрөг, үйлчилгээний тендер шалгаруулалт 4 хувь буюу 1.0 их наяд төгрөг байна.


2023 онтой харьцуулахад ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын төсөвт төсөвт өртөг 2.7 дахин нэмэгдсэн, барааны худалдан авалт 22.6 хувиар, харин үйлчилгээний хувьд 2.4 дахин өсөлттэй байна.

2024 онд ажил төсөвт өртгийн ихэнх буюу 77 хувийг ажил гүйцэтгэх тендер шалгаруулалт эзэлж байна. Энэ нь томоохон дэд бүтэц, барилга байгууламж, бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөртэй холбоотой байна.

- **Тендер шалгаруулалтын арга:**

Тайлант хугацаанд зарлагдсан тендерийг тендер шалгаруулалтын аргаар ангилж үзвэл нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 8,531 буюу 48.16 хувь, харьцуулалтын аргаар 8,256 буюу 46.58 хувь, гэрээ шууд байгуулах аргаар 907 буюу 5.12 хувь, нэг эх үүсвэрийн аргаар 20 буюу 0.13 хувь, ерөнхий гэрээний аргаа 3 тендер шалгаруулалт зохион байгуулагдсан байна. Нийт тендер шалгаруулалтын 95 хувь нь нээлттэй тендер шалгаруулалтын арга болон харьцуулалтын аргаар зохион байгуулагдсан байна (график 6).

График 6. Зарлагдсан тендер тендер шалгаруулалт /аргаар/



Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”-т харьцуулалтын аргаар худалдан авах төсөвт өртгийн дээд хязгаарыг ажил 150.0 сая төгрөг, бараа, үйлчилгээ 100 сая төгрөг гэж тусгасан.

Нийт зарлагдсан тендер шалгаруулалтын 46.6 хувийг харьцуулалтын аргаар зохион байгуулагдсан байгаа нь 150.0 сая төгрөгөөс бага өртөгтэй тендер шалгаруулалт олон байгааг харуулж байна.

Нээлттэй тендер шалгаруулалтын арга болон харьцуулалтын аргын дагуу зохион байгуулсан тендер шалгаруулалтыг төсөвт өртөг болон тоо хэмжээгээр авч үзвэл нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарлагдсан төсөл арга хэмжээний нийт төсөвт өртөг 25.2 их наяд төгрөг буюу 97.3 хувь, харьцуулалтын аргаар зохион байгуулагдсан төсөл арга хэмжээний төсөвт өртөг 0.5 их наяд төгрөг буюу 2 хувь, бусад арга 0.7 хувийг тус тус эзэлж байна.

Үүнээс үзэхэд төрийн худалдан авах ажиллагааны 95 хувь нь ил тод, нээлттэй, өрсөлдөх тэгш боломжийг хангасан байдлаар зохион байгуулагдсан байна.

Тендер шалгаруулалтын арга хэрэглэсэн байдлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын ангиллаар авч үзвэл:

1.Нээлттэй тендер шалгаруулалт нь хамгийн өргөн хэрэглэгддэг арга бөгөөд бүх ангилалд 47-66 хувийг эзэлж байна.

2.Харьцуулалтын арга нь төсвийн ерөнхийлөн захирагч нараас хамааран 33-64%-ийг эзэлж байна. Тус арга нь бусад аргуудтай харьцуулахад богино хугацаанд шийдвэр гаргах боломжийг олгодог, босго үнээс хэтрээгүй төсөвт өртөгтэй үед хэрэглэгддэг. Энэ аргыг орон нутаг болон бусад төсвийн ерөнхийлөн захирагч нар түлхүү ашигласан байна.

3.Гэрээ шууд байгуулах арга нь хуулийн 35 дугаар зүйлд нөхцөлд хэрэглэгддэг бөгөөд орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нар тус аргыг 907 удаа ашигласан байна.

4.Нэг эх үүсвэрийн аргыг хуулийн 36 дугаар зүйлд заасан нөхцөлд хэрэглэхээр зохицуулсан ба тус аргын дагуу хамгийн цөөн буюу 3 тендер шалгаруулалт зохион байгуулагдсан байна.




График 7. Тендер шалгаруулалтын аргын хэрэглээ /ТЭЗ-аар/

- Тендер шалгаруулалт зарлахаар төлөвлөсөн хугацаа ба зарласан хугацаа:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэгт “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр


ашигтай төлөвлөж, батална” гэж, мөн Сангийн сайдын 2023 оны А/250 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.11-д “Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах...” гэж заасан байдаг.

Төсвийн ерөнхийлөн захирагч нар 2024 онд 22,481 тендер шалгаруулалт зохион байгуулахаар тусгаж, 17,718 тендер шалгаруулалт зарласан. Төлөвлөлт болон хэрэгжилтийг хугацааны хувьд харьцуулж үзвэл нийт тендер шалгаруулалтын 22 хувийг 1 дүгээр сард, 23 хувийг 2 дугаар сард, 16 хувийг 3 дугаар сард зарлахаар төлөвлөсөн боловч 1 дүгээр сард 5 хувийг, 2 болон 3 дугаар сард тус тус 14 хувийг зарласан буюу захиалагч нар тендер шалгаруулалтыг төлөвлөсөн хугацаандаа зарлахгүй байгаа нь төсөл арга хэмжээний хэрэгжилтийн хугацаа хойшлох нэг шалтгаан болж байна (График 8).

Тендер шалгаруулалтыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн эсэхийг үзэхэд төлөвлөгөөгөөр захиалагч нар тендер шалгаруулалтыг 1, 2 дугаар саруудад эхлүүлэхээр төлөвлөж баталсан байх боловч хэрэгжилтийг авч үзвэл тендер шалгаруулалтыг 3, 4, 5, 6 саруудад эхлүүлсэн байгаа нь батлагдсан төлөвлөгөөг мөрдөж ажилладаггүй бөгөөд төсвийн жил дундаа орсон байхад тендер шалгаруулалт зарлаж эхэлдэг байна.

Дээрх хандлага орон нутаг, яамд, нийслэл, төрийн өмчит компанийн хувьд ижил байгаа бөгөөд жилийн 6-12 дугаар сард төлөвлөснөөс олон тооны тендер шалгаруулалтыг зарласан байна.

График 8. Тендер шалгаруулалтын төлөвлөлт ба хэрэгжилт /хугацаагаар/



Захиалагч тендер шалгаруулалтыг жилийн хоёрдугаар хагаст зарлах нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг мөрдөхгүй байгааг харуулахын зэрэгцээ, богино хугацаанд олон тендер шалгаруулалт зэрэг зохион байгуулах шаардлага үүсгэсэн байна.

Өөрөөр хэлбэл, жилийн тодорхой хугацаанд олон тендер шалгаруулалтыг нэгэн зэрэг зарлах нь оролцогч, нийлүүлэгч, гүйцэтгэгчийн ачааллыг нэмэгдүүлж, өрсөлдөөн багасах магадлалтайгаас гадна оролцогчгүйгээс шалтгаалж тендер шалгаруулалт амжилтгүй болох эрсдэл үүсгэж байна.

Тухайлбал, 2024 онд 17,718 тендер шалгаруулалт зохион байгуулахад цахим системд 30,698 удаа зарлал нийтлэгдсэн. Цахим системд нийтлэгдсэн зарлалаас үзэхэд нийт зарлалын 20,348 буюу 66 хувь нь оролцогчтой, 10,350 буюу 34 хувь нь оролцогчгүй байна. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад оролцогчгүй зарлалын тоо 10 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нар тендер шалгаруулалтыг төлөвлөсөн хугацаандаа зарлаж байгаа эсэхийг сүүлийн таван жилийн байдлаар график 9-д хувиар харуулав.




График 9. Тендер шалгаруулалтын хугацаа хоцролтын байдал


Сүүлийн таван жилийн хугацаанд тендер шалгаруулалтын 20 орчим хувь нь хугацаандаа зарлагдаж байна. Хугацаандаа зарлагдаагүй тендер шалгаруулалт нь төсвийн ерөнхийлөн захирагчаас үл хамааран ойролцоо түвшинд байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын 80 орчим хувь нь заасан хугацаанаас хоцорч зарладаг байна.

- Тендер шалгаруулалт зарласан байдал:

Хуульд зааснаар тендер шалгаруулалтад нэг ч оролцогч тендер ирүүлээгүй, эсвэл ирүүлсэн тендерүүд захиалагчийн тогтоосон шаардлага хангахгүй тохиолдолд бүх тендер шалгаруулалтаас татгалзаж тухайн тендер шалгаруулалтыг дахин зарлах нөхцөл үүсдэг. Ийнхүү дахин зарласан тохиолдолд төсөл арга хэмжээний эхлэх хугацаа хойшилж, төлөвлөсөн хугацаандаа хэрэгжих боломжгүй болдог.

Тайлант хугацаанд зарласан нийт тендер шалгаруулалтын зарлагдсан байдлыг график 10-д үзүүлэв. Дахин зарласан тендер шалгаруулалтын тоо 2024 онд 31.6%-аар нэмэгдсэн бөгөөд 2023 онтой харьцуулахад дахин зарлах байдал буураагүй бөгөөд 1 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

График 10. Тендер шалгаруулалт тоо ба дахин зарласан байдал



Дахин зарлаж буйн хэд хэдэн шалтгаантай байна. Үүнд: Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт хэт өндөр шалгуур заах, алдаатай, буруу боловсруулах, үнэлгээг буруу хийх зэрэг шалтгаанаас үүдэн амжилтгүй болж байгаа бол төсөл арга хэмжээний төсөвт өртгийг бодитой тооцоогүйгээс шалтгаалан оролцогч орж ирэхгүй тохиолдол ч байна.

- Тендер шалгаруулалтын үр дүн гарсан хугацааны талаар:

Улсын хэмжээнд тендер шалгаруулалт зарласан хугацаанаас захиалагчийн шийдвэр гарах хүртэл дундаж хугацаа 2023 онд **34.1** өдөр байсан бол 2024 онд **28.4** өдөр болж буурсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгаар тендер шалгаруулалт зарлах хугацааг нээлттэй тендер шалгаруулалтын аргын хувьд ажлын 15-аас багагүй өдөр, харьцуулалтын аргын хувьд ажлын 7-оос багагүй өдөр байх гэж заасантай холбоотой байна.





График 11. Тендер шалгаруулалт зарласнаас захиалагчийн шийдвэр гарах хүртэлх дундаж хугацаа

Дээрх дундаж үзүүлэлт тендер шалгаруулалтын аргаас хамаарч ялгаатай байна. Тухайлбал нээлттэй тендер шалгаруулалт 2023 онд **47.2** өдрөөс 2024 онд **38 өдөр**, харьцуулалтын аргын хувьд 2023 онд **22.5** өдрөөс 2024 онд **19.9** өдөр болж тус тус буурсан үзүүлэлттэй байна (график 11).

- **Тендер шалгаруулалтад оролцогч нарын талаар:**

Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтад зааснаар тендер ирүүлсэн аж ахуй эрхлэгчийг оролцогч гэж үздэг. Тендер шалгаруулалт амжилтгүй болох тухай бүр зарлал нийтлэгддэг бөгөөд тайлант хугацаанд 17,718 тендер шалгаруулалт зохион байгуулахад нийт 30,698 зарлал нийтлэгдсэн. Үүнээс 20,348 буюу 66 хувь оролцогчтой, 34 хувь нь оролцогчгүй байна. Оролцогчгүй зарлалын тоо өнгөрсөн онтой харьцуулахад 10 хувиар нэмэгдсэн байх ба энэ нь тендер шалгаруулалтын тоо 28 хувиар нэмэгдсэн боловч оролцогчийн тоо харьцангуй бага буюу 563 (9 хувь)-аар өссөнтэй холбоотой байна. 2020-2024 оны хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцогч нарын болон илгээсэн тендер, түүний дунджийг дараах график 12-т харуулав.

График 12. Оролцогчийн тоо, нийт илгээсэн тендер



Худалдан авах ажиллагааны цахим системээр 2024 онд зарласан тендер шалгаруулалтад 7,184 оролцогч давхардсан тоогоор 60,595 тендер илгээсэн байна. Нэг оролцогчийн илгээсэн дундаж тендерийн тоо 2023 онд 6 байсан бол 2024 онд 8 болж нэмэгдсэн байна. Энэ нь оролцогчдын идэвхжил нэмэгдэж байгааг харуулж буй ч оролцогчдын тооны өсөлт (9% нэмэгдсэн) нь тендер шалгаруулалтын тооны өсөлттэй (28%) харьцуулахад бага байгаа нь өрсөлдөөн багасаж байгааг илтгэж байна.

- Худалдан авах ажиллагааны цахим системд гэрээний мэдээлэл оруулсан байдал:

Хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсэгт “Захиалагч худалдан авах гэрээ, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэж, олон нийтэд нээлттэй байршуулна.” гэж, хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7 дахь заалтад “худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх” гэж тус тус заасан байна.




График 13 13.Бүртгэгдсэн гэрээний мэдээллийн тоо ба төсөвт өртөг (тэрбум төгрөг)

Төсвийн ерөнхийлөн захирагч нар 2024 онд 25,981.9 төсөвт өртөгтэй 17,718 тендер шалгаруулалт зарласан бол цахим системд 8,709.1 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 3808 оролцогчтой байгуулсан 10,417 гэрээний мэдээлэл бүртгэгдсэн байна. 2023 онтой харьцуулахад (5,515.2 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 7,040 гэрээний мэдээлэл бүртгэгдсэн) 2024 онд гэрээний мэдээлэл бүртгэх байдал нэмэгдсэн байгаа боловч захиалагч нар тендер шалгаруулалтын үр дүнд байгуулсан гэрээний мэдээллийг цахим системд бүрэн нийтлэхгүй хэвээр байна.

- Захиалагчийн шийдвэртэй холбогдуулан гаргасан гомдлын шийдвэрлэгдсэн байдал:

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт зааснаар Сангийн яам захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн гомдлыг уг шийдвэр гарснаас хойш ажлын таван өдрийн дотор хүлээн авч, ажлын 10 хоногт хянан шийдвэрлэдэг.

Тайлант хугацаанд 1544 тендер шалгаруулалттай холбогдуулан 1066 оролцогчоос гаргасан 2176 гомдлыг хянан шийдвэрлэсэн нь 2023 оноос 31.7%-аар өссөн үзүүлэлттэй байна. Дараах хүснэгтэд оролцогч нараас Сангийн яаманд ирүүлсэн гомдлын талаарх мэдээллийг 2022-2024 оны байдлаар харуулав.

Хүснэгт 3. Гомдлын мэдээлэл /2022-2024 он/

Он	Нийт тендер шалгаруулалт	Гомдол гарсан тендер шалгаруулалт	Нийт ТШ-д гомдлын эзлэх хувь	Гомдол гаргасан оролцогч	Ирүүлсэн гомдол (давхардсан тоогоор)	Гомдлын үндэслэлтэй хувь
2022 он	12576	734	6%	548	968	82.0%
2023 он	13647	994	7%	811	1487	73.6%
2024 он	17718	1544	9%	1066	2176	80.6%

Нийт тендер шалгаруулалтын тоо 2023 онд 13,647 буюу 8.5 хувиар, 2024 онд 17,718 буюу 29.8 хувиар тус тус нэмэгдсэн бол гомдол гарсан тендер шалгаруулалт 2023 онд 260 буюу 35.5 хувиар, 2024 онд 550 буюу 55.3 хувиар тус тус өссөн байна. Харин нийт тендер шалгаруулалтад гомдол гарсан тендер шалгаруулалтын хувь 2023 онд 7 хувь, 2024 онд 9 хувь болсон байна.

Үүнээс үзэхэд нийт тендер шалгаруулалтын тооны өсөлттэй харьцуулахад гомдол гарч буй тендер шалгаруулалтын өсөлтийн хувь илүү байгаа нь шалгараагүй оролцогч нар захиалагчийн шийдвэрийг зөвшөөрөхгүй байх хандлага өссөн ажиглагдаж байна.

Нөгөөтээгүүр оролцогч нараас ирүүлсэн гомдлын хянан шийдвэрлэгдсэн байдалтай харьцуулан үзэхэд 2024 онд ирсэн гомдлын 80.6% нь үндэслэлтэй гэж шийдвэрлэгдсэн нь 2023 оны 73.6%-тай харьцуулахад өссөн үзүүлэлттэй байх ба захиалагч хуульд нийцээгүй шийдвэр гаргаж байгаа тохиолдол нэмэгдсэнийг харуулж байна.

- Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийн талаар:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар тендерт оролцохдоо илт худал мэдээлэл ирүүлсэн, эсхүл бусад этгээдийн баримт бичгийг өөрчилж тендер ирүүлсэн, гэрээний үүргээ гүйцэтгээгүйн улмаас гэрээ цуцлагдсан, гэрээнээс татгалзсан, эсхүл захиалагч хохирол барагдуулахыг шаардсан, мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, байцаагч тогтоосон, давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд хөгжлийн бэрхшээлтэй ажилтныг зохих ёсоор оролцуулаагүй, эсхүл давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй тохиолдолд оролцогчийг тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах үндэслэл болдог.

Төсвийн ерөнхийлөн захирагч, захиалагч аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс ирүүлсэн гомдол мэдээлэлд үндэслэн 2024 онд Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга бөгөөд Худалдан авах ажиллагааны улсын ерөнхий байцаагчийн баталсан 5 удаагийн удирдамжаар нийт 84 хуулийн этгээдийг хамруулан хянан шалгалтыг хийж гүйцэтгэсэн бөгөөд үүнээс 45 хуулийн этгээдийг Сангийн сайдын 2 удаагийн тушаалаар тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлаж, олон нийтэд мэдээлж ажиллалаа.

- **Шууд худалдан авалтын талаар:**

Шууд худалдан авалт хийх босго үнэ 2013-2021 оны хооронд 10 сая төгрөг байсан бөгөөд Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолыг хавсралтаар шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг 20 сая болгон нэмэгдүүлж баталсан.

Захиалагч нарын шууд худалдан авалт хийсэн төсөвт өртөг болон тоо хэмжээг сүүлийн 5 жилээр харьцуулан гаргалаа. (График 13)




График 14. Шууд худалдан авалт

Дээрх графикаас харахад шууд худалдан авалтын төсөвт өртөг болон тоо хэмжээ нь жилээс жилд өссөн үзүүлэлтэй байх бөгөөд төсөвт өртөг нь 2024 онд 2 дахин буюу 119 хувиар огцом өссөн байна.

Дараах хүснэгтээр шууд худалдан авах ажиллагаа хийсэн төсвийн ерөнхийлөн захирагчаар ангилан авч үзвэл. (Хүснэгт)

Хүснэгт 4. Шууд худалдан авалт /төсвийн ерөнхийлөн захирагчаар/

Ангилал	Төсөвт өртөг (тэрбум төгрөг)	ШХА-ын тоо
Бусад	3.0	319
Засгийн газар	54.0	5,203
Нийслэл	9.1	631
Орон нутаг	89.6	8,026
ТӨБЗГ	10.1	814
Эрдэнэс монгол нэгдэл	19.1	1,480

Хүснэгтээс харахад орон нутагт хамгийн их буюу 89.6 тэрбум төгрөгийн шууд худалдан авалт хийсэн нь нийт төсөвт өртгийн 48.4 хувийг эзэлж байна. Засгийн газар 54.0 тэрбум, эрдэнэс монгол нэгдэл 19.1 тэрбум төгрөг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтыг газар 10.1 тэрбум, нийслэл 9.1 тэрбум төгрөгийн шууд худалдан авалт хийсэн дүнтэй байна.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН

ТАЙЛАНД ӨГСӨН НЭГДСЭН ДҮГНЭЛТ:

Тайлант хугацаанд нийт 32.0 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 22,481 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт төлөвлөгдсөнөөс 26.0 их наяд төгрөгийн өртөгтэй 17,718 тендер шалгаруулалт зарлагдсан байна. Гүйцэтгэл төсөвт өртгийн хувьд 81 хувь, тендер шалгаруулалтын тоогоор 79 хувьтай байгаа нь өмнөх онуудтай харьцуулахад өссөн үзүүлэлт байна. Гэсэн хэдий ч нийт төлөвлөгдсөн тендер шалгаруулалтын 19 хувь буюу 6.1 их наяд төгрөгийн өртөгтэй 4,700 тендер зарлагдаагүй байх бөгөөд сүүлийн таван жилийн хугацаанд гүйцэтгэл 75-80 хувьтай байна.

Худалдан авах ажиллагааны төсөвт өртгийн өсөлт өнгөрсөн онд 116 хувьд хүрч, тендер шалгаруулалтын тоо 29.8 хувиар нэмэгдсэн нь томоохон төсөл хөтөлбөрүүд, тухайлбал Нийслэлээс зарласан “Нийтийн тээврийн “Метро”-гийн бүтээн байгуулалт, “Эрдэнэс Тавантолгой”-н хөрс хуулалт зэрэг төсөл арга хэмжээнүүд төсөвт өртгийн өсөлтөд голлон нөлөөлсөн байна.

Нийт тендер шалгаруулалтын 89.1 хувь нэг тэрбум хүртэлх төсөвт өртөгтэй, харин 10.9 хувь нэг тэрбумаас дээш өртөгтэй байсан байна. Нөгөөтгээгүүр нэг

тэрбумаас дээш төсөвт өртөгтэй тендер шалгаруулалт нь нийт төсөвт өртгийн 90 хувийг эзэлж байна.

Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний 43 хувийг өөрийн хөрөнгө, 33 хувийг орон нутгийн төсөв, 21 хувийг улсын төсөв бүрдүүлж байна. Санхүүжилтийн бүтэц нь өмнөх онтой харьцуулахад өөрчлөгдөж, орон нутгийн төсвийн эзлэх хувь нэмэгдсэн байна. Орон нутгийн төсвөөс санхүүжилттэй тендер шалгаруулалтын төсөвт өртөг нэмэгдэхэд Нийслэл болон Өмнөговь аймгийн зарласан тендер шалгаруулалт голлох нөлөө үзүүлсэн байна.

Нээлттэй тендер шалгаруулалт (48.16%) болон харьцуулалтын арга (46.58%) нь нийт тендер шалгаруулалтын 95 хувийг эзэлж байгаа нь тендер шалгаруулалтыг ил тод, нээлттэй зарлаж байгааг харуулж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч, захиалагч нар тендер шалгаруулалтыг төлөвлөсөн хугацаандаа зарлахгүй байгаа нь төслийн хэрэгжилт хоцрох гол шалтгаан болж байна. 2024 оны эхний улиралд нийт тендер шалгаруулалтын 73 хувийг зохион байгуулахаар төлөвлөсөн боловч зөвхөн 38 хувь нь эхэлсэн байх бөгөөд орон нутаг, нийслэл, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс үл хамааран нийт тендер шалгаруулалтын 80 хувь хугацаа хоцорч эхэлж байна.

Түүнчлэн, 2024 онд нийт тендер шалгаруулалтын 31.6 хувь нь дахин зарлагдсан нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна. Дахин зарлах гол шалтгаанууд нь тендерийн баримт бичгийн алдаа, хэт өндөр шалгуур, төсөвт өртгийн бодит бус тооцоо зэрэгтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд тендер шалгаруулалттай холбогдуулан ирүүлсэн гомдлын 80.6 хувь нь үндэслэлтэй гэж шийдвэрлэгдсэн байх ба захиалагчийн гаргасан шийдвэрүүд хууль журамд нийцэхгүй, тендер шалгаруулалтын баримт бичиг боловсруулах, тендер хянан үзэх, үнэлгээ хийх, шийдвэр гаргалтыг сайжруулах шаардлагатай гэж харагдаж байна.

Сүүлийн 5 жилийн статистик үзүүлэлтээс харахад шууд худалдан авалтын төсөвт өртөг болон тоо хэмжээ жилээс жилд эрчимтэй өссөн байна. 2024 онд шууд худалдан авалтын төсөвт өртөг 2 дахин буюу 119 хувиар огцом өссөн байна. Шууд худалдан авалтын төсөвт өртгийн тал хувийг (48.4%) орон нутаг бүрдүүлж байгаа нь орон нутгийн төсөв 20 сая төгрөг дотор хуваагдаж байгааг харуулж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсэг болон 48 дугаар зүйлийн 48.2.7 дахь заалтад заасны дагуу худалдан авах гэрээний мэдээллийг цахим системд бүртгэж, олон нийтэд нээлттэй байршуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг захиалагч нарт хариуцуулсан байдаг. Гэвч 2024 оны худалдан авах ажиллагааны тайлангаас харахад энэ үүргийн хэрэгжилт хангалтгүй хэвээр байна. Цахим системд бүртгэгдсэн мэдээлэл дутуу байгаагаас худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл олон нийтэд бүрэн нээлттэй бус байна.